

БАТЛАВ  
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА И БАТТӨГС

2024 оны 01 дүгээр сарын 29 өдөр

ГЭР ХОРООЛЛЫН ГУДАМЖ, ТАЛБАЙ ХУСАЖ, ТЭГШЛЭХ АЖИЛ (БЗД, 2, 4, 21, 27, 29  
ДҮГЭЭР ХОРОО)-ЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/1491 дугаартай захирамж;
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Баянзүрх дүүргийн 2, 4, 21, 27, 29 дүгээр хорооны нутаг дэвсгэрт төвөгшил ихтэй 33,709 м2 гудамж зам талбайг хусаж, тэгшлэх ажил;
3	Засварын ажлын зохион байгуулалт	<p>1. <u>Засварын ажлын хуваарь, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах:</u></p> <ul style="list-style-type: none"><li>- Ажлыг гүйцэтгэхдээ өөрийн гүйцэтгэж байгаа ажил, явганаар зорчиж байгаа иргэдэд бэрхшээл учруулахгүй байхаар анхааруулах, хориглох тэмдэг, засварын ажил явагдаж буйг мэдээлэх тэмдгүүдийг засварын ажил хийгдэж байгаа орчинд зайлшгүй байрлуулна.</li><li>- Шөнийн цагаар гэрэлтүүлэх хэрэгсэл болон, гэрэл ойлгогч, цацруулагчтай тууз зэргийг ажлын талбайд хангалттай байрлуулах шаардлагатай. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, түр зам гаргаж байнгын арчилгаатай байлган оршин суугчдын ая тухтай зорчих байдлыг ханган ажиллаж зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч барилгын ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай.</li><li>- Шороон зам хусаж тэгшлэх үед инженерийн шугам сүлжээ, цахилгааны кабел гэмтээх тохиолдолд гүйцэтгэгч хариуцлага хүлээх бөгөөд урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг ханган ажиллана. НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар баталсан “Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага”-ыг баримтлан гүйцэтгэх.</li></ul> <p>2. <u>Засварын ажил гүйцэтгэх технологи:</u></p> <ul style="list-style-type: none"><li>- Засвар хийх замын шороо шаврыг цэвэрлэж, тохиромжгүй хөрсийг хусаж зайлуулах. Хусаж тэгшилсэн материалыг зайлуулаад 20мм-с томгүй ширхэглэлтэй дээд үеийн хайрган материалаар хонхрыг дүүргэж автогрейдерээр жигд тэгшлэн, замын чийгийг сэргээж, өөрөө явагч 12-18 тн даацтай далангийн индүүгээр усалгаатай нягтруулна. Нягтралын үр дүн 95%-иас багагүй байна.</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Материал: Материал олборлох талбай ба замын ухмалаас далан барих дүүргэх зориулалтаар ашиглахаар авсан шороо хайрга, элс эсвэл эдгээр материалын холимгийг дүүргэгч материал гэнэ.</li> <li>- Дүүргэгч материал нь талбайн туршилтын явцад нягтруулах үед сул, тогтвор муутай эсвэл өөр бусад хүндрэлүүд үзүүлэх ёсгүй бөгөөд ширхэглэлийн зохистой найрлагатай байх.</li> <li>- Намаг шавартай газрыг чулуугаар дүүргэх, чулууны том хэмжээ 25мм-ээс хэтрэхгүй, 150 мм-ээс илүүгүй зузаан үеэр жигд дэвсээд дүүргэх материалыг 500 мм-с илүүгүй зузаанаар нягтруулна.</li> <li>- Хөдөлгөөн ихтэй гудамж зам дээр замын ажилчид болон зорчигчид аль алинд нь аюултай тул засварын ажил хийж байх үед хаалт, замын тэмдэг туг дарцаг байрлуулах зэргээр хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авна.</li> </ul>
4	Зураг төслийн бүрдэл	<p><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэмжилтийн зураг, төсвийг боловсруулж, холбогдох байгууллагуудтай зөвшилцөн батлуулах;</li> </ul>
5	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгох;</li> </ul>
6	Зураг төслийн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага байх;</li> </ul>
7	Хөрөнгө оруулагч	<ul style="list-style-type: none"> <li>- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар;</li> </ul>
8	Инженерийн хангамж	<ul style="list-style-type: none"> <li>- Эрх бүхий байгууллагаас холбогдох саналыг авч зураг төсвийг боловсруулан угсралтын ажлыг хийж гүйцэтгэх;</li> </ul>
9	Онцгой нөхцөл	<p><u>Анхаарах зүйл:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт үнийн санал ирүүлэхдээ газар дээр нь судалж, ажлын тоо хэмжээг тооцож ирүүлэх;</li> <li>- Хэмжилтийн зураг төсвийг боловсруулж, баталгаажуулсны дараа угсралтын ажлыг эхлүүлэх;</li> <li>- Тухайн хусаж, тэгшлэх байршлуудын хамрах хэсгүүдийн орчныг болон орц, гарцыг саадгүй, тэгш гадаргуу болгон цэвэрлэх;</li> </ul>

10	Төлөвлөлтөд тавигдах шаардлага	<p><u>Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар;</li> <li>- Холбогдох бусад байгууллагатай;</li> </ul>
11	Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөв боловсруулах	<p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;</li> <li>- Барилгын тухай хууль;</li> <li>- Газрын тухай хууль;</li> <li>- Хот байгуулалтын тухай хууль;</li> </ul> <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Хотын стандарт-Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих шаардлага” UCS 0901B стандартыг мөрдөх;</li> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/;</li> <li>- Авто замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын техникийн шаардлага;</li> <li>- Авто замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын үйлдвэрлэлтийн жишиг норм;</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм;</li> </ul> <p><u>Төсөл, хөтөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;</li> <li>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;</li> <li>- Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;</li> </ul>
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;</li> </ul>

ХЯНАСАН:  
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН  
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДАВААСАМБУУ

БОЛОВСРУУЛСАН:  
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.БАТБАЯР